



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар Б/16


Батширээт сум

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1, “Төсвийн тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь заалт, “Төрийн албаны тухай хууль”-ийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилт 76,7%-тай дүгнэгдсэн тул соёлын төвийн дарга Чимэддоржийн Болорцэцэгт үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 40%-иар олгосугай.
2. Дээрх зардлыг цалингийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Н.Одончимэг)-т зөвшөөрсүгэй .

ЗАСАГ ДАРГА БАЛТАНГЭРЭЛ



232201093